



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/010/-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитор А.Пүрэвцэцэг Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХГБХХГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.25 № 160
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА М.ДАВААЦЭРЭН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын 2024 оны жилийн эцсийн үлдэгдлийн дүнг баталгаажуулаагүй, ЗДТГ-ын хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний бүртгэл тооцооны программын дүнгээс 15,516.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох.сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-тай нийцээгүй,

бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын төсөвт 20 нэр төрлийн орлогоор 386,600.5 мянган төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 575,839.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөө нийт дүнгээр 48.9 хувиар давж биелжээ.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 1,917,653.7 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,515,111.1 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 402,542.6 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Хангай сумын Засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 13 үндсэн зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 83.2 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	734,697.60	911,312.70
31	Мөнгөн хөрөнгө	301,025.40	601,111.70
33	Авлага	345,416.60	238,245.70
35	Бараа материал	47,430.60	55,955.30
36	Нөөцийн бараа	40,825.00	16,000.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,617,436.10	2,712,612.20
39	Үндсэн хөрөнгө	2,617,436.10	2,712,612.20
39200	Биет хөрөнгө	2,538,164.10	2,634,015.20
39300	Биет бус хөрөнгө	79,272.00	78,597.00
3	Нийт хөрөнгийн дүн iii=i+ii	3,352,133.60	3,623,924.90
4	Нийт өр төлбөр	-	550.00
41	Богино хугацаат өр төлбөр	-	550.00
41300	Өглөг	-	550.00
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,352,133.60	3,623,374.90
51	Засгийн газрын хувь оролцоо	3,352,133.60	3,623,374.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	356,050.10	356,050.10
51200	Хуримтлагдсан үр дүн	2,930,065.60	3,201,306.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,018.00	66,018.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,352,133.60	3,623,924.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,645,849.00	1,873,975.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	324,952.80	532,061.80
110	Орлогын албан татвар	236,391.30	484,339.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	236,347.00	484,240.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	44.2	99
113	Хөрөнгийн албан татвар	60,773.00	21,336.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,788.60	26,386.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	378,115.60	183,101.80
120	Нийтлэг татварын бус орлого	378,115.60	183,101.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,942,780.60	1,158,811.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,019,356.30	1,279,446.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,007,553.10	1,279,446.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,012,771.90	1,245,054.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,633.30	656,080.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,768.60	80,567.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,642.20	201,571.30
2104	Хангамж, бараа материалын зардал	48,661.70	69,384.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,286.60	37,819.20

Архангай аймгийн Хангай сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	19,560.20	25,779.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	171,080.20	40,682.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,139.00	133,170.20
212	ТАТААС	3,635.00	3,231.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	991,146.30	31,160.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,803.20	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	626,492.70	594,529.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	362,270.80	323,288.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	264,221.80	271,241.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,377,977.90	1,818,655.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	324,952.80	532,061.80
110	Орлогын албан татвар	236,391.30	484,339.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	236,347.00	484,240.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	44.20	99.00
113	Хөрөнгийн албан татвар	60,773.00	21,336.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,788.60	26,386.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,480.60	16,924.20
1181	Газрын төлбөр	230.40	270.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	7,077.60	9,191.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	110,244.60	127,781.90
120	Нийтлэг татварын бус орлого	110,244.60	127,781.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,942,780.60	1,158,811.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,807,275.80	1,174,880.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,807,275.80	1,174,880.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,631.10	1,122,267.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,633.30	656,080.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,768.60	80,567.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,642.20	206,757.30
2104	Хангамж, бараа материалын зардал	41,075.80	41,552.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,050.00	37,120.30
2107	Томилолт, зочны зардал	19,560.20	25,779.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	173,066.60	45,423.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,834.30	28,987.30
212	ТАТААС	3,999.50	5,822.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	991,645.30	46,790.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	570,702.10	643,775.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	377,553.70	343,688.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	377,553.70	343,688.90
2200	Дотоод эх үүсвэрээр	377,553.70	343,688.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(377,553.70)	(343,688.90)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(90,000.00)	-

Архангай аймгийн Хангай сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	90,000.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	103,148.40	300,086.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,877.00	301,025.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	301,025.40	601,111.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,087,911.80	3,087,911.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,087,911.80	3,087,911.80
9	Тайлант үеийн үр дүн	264,221.80	264,221.80
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,352,133.60	3,352,133.60
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,352,133.60	3,352,133.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,352,133.60	3,352,133.60
19	Тайлант үеийн үр дүн	271,241.30	271,241.30
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,623,374.90	3,623,374.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,917,653.70	1,515,111.17	402,542.53	20.99
21	Урсгал зардал	1,427,667.20	1,191,871.62	235,795.58	16.52
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,359,233.20	1,139,258.60	219,974.60	16.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	769,826.10	656,080.69	113,745.41	14.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,139.20	80,567.01	15,572.19	16.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	218,851.40	206,757.33	12,094.07	5.53
2104	Хангамж, бараа материалын зардал	49,514.40	41,552.69	7,961.71	16.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,818.20	57,569.70	4,248.50	6.87
2107	Томилолт, зочны зардал	26,000.00	25,779.00	221.00	0.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,083.90	41,964.87	11,119.03	20.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,000.00	28,987.30	55,012.70	65.49
212	Татаас	6,000.00	5,822.56	177.44	2.96
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	6,000.00	5,822.56	177.44	2.96
213	Урсгал шилжүүлэг	62,434.00	46,790.46	15,643.54	25.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,750.00	15,750.00	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,684.00	31,040.46	15,643.54	33.51
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	364,261.50	323,239.54	41,021.96	11.26

Архангай аймгийн Хангай сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	125,725.00	0	125,725.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,917,653.70	1,550,347.46	367,306.24	19.15
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,522,478.80	1,424,850.52	97,628.28	6.41
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	395,174.90	125,496.94	269,677.96	68.24
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	132,221.79	(132,221.79)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	167,458.08	(167,458.08)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	27	1.00	3.57

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй 15516.2 мянган төгрөгийн нэг зөрчил¹ илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 15,516.2 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн албаны хяналтын үр дүнтэй холбоотой санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын 11,946.6 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт 27,462.8 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **21,573.6** мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Тайлант оны ХХС-н зээлийн үлдэгдлийг тулган шалгахад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй, сумын ХХС хариуцсан мэргэжилтний бүртгэл тооцооны программын дүнгээс 15,516.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 15 дугаар зүйлийн 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын нягтлан бодох бүртгэлээрх авлагын үлдэгдлийг Хоршоо жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний программын бүртгэлээрх дүнтэй тулган шалгах ажлын хэсгийг томилж, 2 бүртгэлээрх зөрүүг арилгах, зээлдэгч тус бүрээр үлдэгдлийг тулган баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авах зөвлөмжийг хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

5.2.1. Дотоод хяналттай холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд сумын засаг даргын санхүүгийн алба, төрийн сангаас өдөр тутам төсвийн гүйлгээнд тавих хяналт муу байгаагаас төсвийн шууд захирагч нарын тайланд 11,946.6 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.5, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.7 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг даргын дотоод хяналт, төсвийн байгууллагуудын гүйлгээнд сумын санхүүгийн алба, төрийн сангаас тавих өдөр тутмын хяналтын үр дүнг сайжруулах арга хэмжээг авч үр дүнг үнэлэх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС-тай холбоотой	1	15,516.2			1	15,516.2	-	-	-	-	-	-
Дотоод хяналт	1	11,946.6					1	11,946.6				
НИЙТ ДҮН	2	27,462.8			1	15,516.2	1	11,946.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Архангай аймгийн Хангай сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Шилэн данс		-	-	-		-	-	-		-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

5. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:													
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
здтг	5	11,172.2	1	2,160.0	4	9,012.2										
итх	1	774,4	1	774,4												
ХХС	1	15,516.2			1	15,516.2										
Дотоод хяналт	1	-					1	-								
ОНХС	-	-														
Дүн	8	27,462.8	2	2,934.4	5	24,528.4										